

08 дугаар сарын үйл ажиллагааны мэдээ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл: Сүхбаатар аймгийн Залуучуудын Холбоо 2021-2024 онд хэрэгжүүлэх “Нутгийн залуучууд” хөтөлбөрийг аймгийн ИТХ-аар батлуулж, сар бүрийн 25-ны өдрийг “Залуучуудыг дэмжих өдөр” болгон зарлаж, залуусын дуу хоолойг, үзэл бодлыг сонсох, тэдэнтэй ярилцах өдөр болгосон. Монгол Улсад залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ой, Сүхбаатар аймгийн Залуучуудын холбоо шинэчлэгдэн хөгжсөний 30 жилийн ой тохиож буйтай холбогдуулан аймгийн удирдлагын зүгээс Залуучуудын Холбоог дэмжиж м2 талбай бүхий шинэ байрны түлхүүрийг гардуулан өглөө.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг Асгат, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт ажиллаж байгаа уул уурхайн үйл ажиллагаатай танилцлаа. Мөн Бичигт боомтод ажиллаж гааль, Мэргэжлийн хяналтын хэлтэс, хилийн цэрэг, цагдаагийн алба хаагч нартай уулзаж ажлын нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдаж байгаа асуудлын талаар сонсож, зарим тодорхой асуудлыг газар дээр нь шийдвэрлэж ажилласан байна.

Мэдээлэл сурталчилгаа: 07 дугаар сарын 31-нээс 08 дугаар сарын 31-ний байдлаар аймгийн ЗДТГ-ын цахим хуудас болон аймгийн томоохон цахим хуудсанд 24500 мэдээ, мэдээллийг 60566 хүнд хүргэв. Цахим хуудсыг дагах дэмжигчид 231 хүнээр нэмэгдсэн байна. Энэ хугацаанд цаг үеийн холбогдолтой мэдээ-18, коронавируст халдвар ковид-19/-ын нөхцөл байдлын мэдээлэлийг шууд лайваар 5 удаа бэлтгэж 2,2 мянган хүнд хүргэв. Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээлэл 12, аймгийн Онцгой комиссын шийдвэр болон аймгийн ИТХ-ын ээлжит бус 5-р хуралдааны хэлэлцсэн асуудал мэдээллийг бэлтгэж телевиз, сонин, цахим хуудас, гэрээт сайтаар түгээв.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас хийгдэж байгаа ажил болон цаг үеийн шинжтэй 60 гаруй мэдээллийг иргэдэд хүргэж ажиллав.

Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

2021 оны 8 дугаар сард улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр болон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоор нийт 26,553.6 сая төгрөг авч, аймгийн төсөвт 5,823.4 сая төгрөгийн орлого орж нийт 32,377.0 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажиллалаа.

08 дугаар сарын байдлаар Улсын төсөвт 1951,9 сая төгрөг төвлөрүүлэхээс 2658,6 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөө 136,2 хувиар, Орон нутгийн нэгдсэн төсөвт 6358,1 сая төгрөг төвлөрүүлэхээс 8905,1 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөө 140 хувиар тус тус биелэж нийт төлөвлөгөө 8310,0 сая.төгрөг төвлөрүүлэхээс 11563,7 сая.төгрөг төвлөрүүлж 139,2 хувиар биелүүлсэн байна.

Аймгийн төсвөөс сумдад 4,220.4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, орон нутгийн төсвийн 13 байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн 56 байгууллагад нийт 27942.4 сая төгрөгийн санхүүжилт олгож байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн явуулж ирсэн.

Статистикийн хүрээнд: Нийгмийн даатгалын шинэчлэгдсэн хуультай холбогдуулан тэтгэвэрт тогтоолгох гэж байгаа иргэдийн өргөдлийн дагуу 25 иргэний малын А дансны мэдээллийг гарган өгсөн.

Өрхөд суурилсан ажиллах хүч, өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаануудын 8-р сарын мэдээлэл цуглуулалтыг хийж, нягтлан шалгах үйл ажиллагаа хийгдэж байна.

Жендэр ба хүрээлэн буй орчин судалгаанд хамрагдах 8 нэгжийн 160 өрхийн утасны дугаар, хаягийн мэдээллийг багийн Засаг дарга нараас тодруулан бэлтгэлийг хангаж ҮСХ-нд хүргүүлсэн. Тухай өрхүүдээс ҮСХ-ноос томилогдсон судлаач нар утсаар холбогдон судалгааг авсан бөгөөд холбогдох боломжгүй байсан Баруун-Урт сумын 25 өрхийн мэдээллийг хэлтсийн 2 мэргэжилтэн, 2 судлаач нар хаяган дээр очиж мэдээллийг цуглуулж байна.

ААНБ-ын үйл ажиллагаанд Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөллийн 8 дугаар сарын судалгааг түүвэрлэгдэн ирсэн 76 ААНБ-аас бүрэн авч ҮСХ-нд дамжуулсан.

Худалдан авах ажиллагааны хүрээнд: “2021 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу 2021 оны 08 дугаар сард tender.gov.mn сайтаар дамжуулан нийт давхцсан тоогоор 20 бараа, ажил, үйлчилгээний тендерийг зарлаад байна. Үүнээс 08 дугаар сард гэрээ байгуулсан 8 , дахин зарласан 3 тендерт тус бүр 2 удаа , үнэлгээ хийгдээгүй байгаа болон хугацаа нь болоогүй тендерүүд байхгүй.

08 дугаар сард нийт 8 бараа, ажил, үйлчилгээний тендерийн үнэлгээг хийж, захиалагч байгууллагад зөвлөмж /6,064,599802 төгрөг/ хүргүүлсэн байна. Хэмнэлт 149,970,198 төгрөг байна.

Хяналт шалгалтын чиглэлээр: Асгат сумын Засаг даргын Тамгын газарт дотоод аудитын шалгалт хийгдэж дууссан ба дотоод аудиторын 6 заалттай зөвлөмж өгсөн байна.

Гурав. Нийгмийн бодлогын хүрээнд:

Боловсрол, Соёл урлагийн чиглэлээр: БМДИ-ээс зохион байгуулсан “Сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад дэмжлэг үзүүлэх нь” боловсролын салбарын багш, удирдах ажилтны 4 өдрийн цахим сургалтад 16 сургууль, 24 цэцэрлэгийн багш, удирдах ажилтнууд хамрагдсан.

Сүхбаатар аймагт ЭЕШ халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан, зохион байгуулалт сайтай, ямар нэгэн алдаа, зөрчилгүй амжилттай болж өнгөрлөө. Шалгалтад БҮТ, аймгийн БСУГ, МХГ, шалгалтын төвийн багш, эмч - ажилтнууд, хянагч багш нар зэрэг 50 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг 4 өдрийн турш ажиллалаа. Энэ онд төгсөгчдөөс 21 сурагч, өмнөх оноос 30 гаруй хүн бүртгүүлсэн боловч шалгалтад ороогүй. Ковидын халдварын улмаас шалгалтад ороогүй шалгуулагч 9 сарын 2-нд болох дараагийн шалгалтад орох юм.

Сүхбаатар аймаг энэ удаагийн шалгалтад урьдчилсан байдлаар шалгуулагчдын хэмжээст онооны дунджаар:

Түүх-644,1 оноогоор 1, Англи хэл - 496,5 оноогоор 7, Биологи - 501,7 оноогоор 15, Газар зүй -567,7 оноогоор 1, Хими - 492,7 оноогоор 15, НТМ- 516,6 оноогоор 7, Математик - 498,3 оноогоор 13, Орос хэл - 630 оноогоор 9, Физик - 500 оноогоор 15, Монгол хэл - 535,4 оноогоор 4-рт тус тус эрэмбэлэгдэж, нийт шалгуулагчдын дундаж оноогоор 6-рт байгаа нь өмнөх жилийн амжилтаа бататгасан, олон зуун сурагч, багш нарын хичээл зүтгэлийн үр дүнг харуулж байна.

Математик, НТМ, Монгол хэлний хичээлээр 4 сурагч 800 оноо авч, математик, физик, биологи, НТМ, англи, орос хэл, монгол хэлний шалгалтад 90-ээс дээш хувийн гүйцэтгэлтэй сурагчдын тоо эрс нэмэгдсэн байна. ЭЕШ-ын дүнг сум, сургууль, бэлтгэсэн багшаар нь ангилан гаргах ажил хийгдэж байна. Эцсийн дүн 9-р сарын шалгалтын дараа нэгтгэгдэж гарна.

2021-2022 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид элсэх сурагчдын бүртгэл цахимаар зохион байгуулагдаж байна.

Соелын өвийн үндэсний төвөөс зохион байгуулсан “Хэрлэнгийн барьяа” уртын дууны анхдугаар уралдаанд Түмэнцогт сумын ардын авьяастан, уртын дууч Ц.Энхжин оролцож дэд байр эзэлсэн амжилт үзүүлсэн.

Хөгжимт жүжгийн театр: Орон нутгийн телевизтэй хамтран урлагийн ажилтны баяр, ахмадын баярыг тохиолдуулсан ТВ контент хийх төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Угсаатны зүйн музей: Түүхийн танхимын үзмэрт шинэчилсэн дэглэлт хийж, Монголчуудын уламжлалт гоёл үзэсгэлэнг дэглэсэн.

Улсын нэгдсэн БМСанд 17 дэсийн 52 үзмэрийн тодорхойлолтыг илгээсэний зэрэгцээ регистр программд 17 дэсийн 52 үзмэрийн тодорхойлолтыг оруулсан байна.

Зэсээр урлахуй сэдэвт үзэсгэлэн шинээр дэглэгдэж 2301 хүний тандалт авсан.

СӨҮТ-өөс ирсэн ажлын хэсэгтэй түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол үнэ цэнэ бүхий дурсгалуудын өнөөгийн бодит байдлын гэрэл зураг болон нэвтрүүлэг, контентийн үйл ажиллагаанд хамтарч ажиллалаа.

Монголын үндэсний ТВ-ээс Дарьганга өв соёлын болон Музейн сийлбэрийн танхимийн бүх үзмэрийн 3D зураг авалт хийсэн.

Нийтийн номын сан: Шинэ номын мэдээ, цахим уншлагыг тогтмол явуулж, Эх хэл тусгаар тогтнол- Цахим орчинд соёл түгээе “Хүн бүр Үндэсний бичиг үсгээрээ уншиж, бичиж чаддаг болохын төлөө” уриан дор монгол бичгийн бичвэрийг байгууллагын цахим хуудсанд тогтмол байршуулж, уншсан хүн comment хэсэгт уншсанаа бичих, мөн уншуулах хүнээ mention хийх зэргээр түгээх ажлыг зохион байгуулан сурталчилж, 360 гаруй мэдээлэл оруулж сурталчилсан байна.

Жил бүр уламжлал болгон тэмдэглэдэг "Номын баяр-2021" арга хэмжээг угтан Онлайн номын үзэсгэлэнг зохион байгуулж байна. Цахим арга хэмжээний хүрээнд “SB Library“ Цахим сэтгүүл”-ийн “Танин мэдэхүйн мэдээлэл”-ийн булангаар Дэлхийн улс орнууд -1.2, "Ширэнгэн ойн дээд давхаргын амьтад", "Нуурын амьдрал", Андын нуруу толгой эргэм өндөрт амьдардаг амьтдын тухай" сэдвээр мэдээлэл бэлтгэн хүргэсэн.

Биеийн тамир, спортын газар: ОУХМ Я.Баатарын нэрэмжит “Монголын олон өдөр-2021” тэмцээнд “Шилийн богд” клубын дугуйн баг тамирчин спортын мастер Э.Жавхланбат 6 алтан медаль авч, “Цагаан цамц”-ны эзэн, Г.Даваамэнд бөөн гараа 120км уралдаанд мөнгөн медаль хүртэж, 3 цаг 04 минутын амжилтаар спортын дэд мастерын болзолыг хангасан амжилт үзүүлсэн байна. Мөн спортын мастер Ч.Наранхүү 2 хүрэл медаль хүртсэн амжилт гаргасан. Багийн гараа 50км түрүүлж алтан медалийн эзэд болсон байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Орон нутгийн хөрөнгө оруулалтаар АНЭ-т нүдний эвэрлэгийн мэс заслын микроскоп, 7 сум, 3 өрхийн ЭМТөвд анхан шатны мобайл технологийг худалдан авч хүлээлгэн өгөв.

"Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн хүрээнд сүрьеэгийн хавьталын илрүүлэг үзлэг зохион байгуулах хамтран ажиллах гэрээ"-ний дагуу Асгат, Дарьганга, Онгон, Халзан сумдад хавьталын үзлэийг зохион байгууллаа.

Коронавируст халдварын цаг үеийн нөхцөл байдлын мэдээллийг өдөр бүр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр иргэдэд хүргэж Коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар анхан шатны эмнэлгүүдэд 3 удаа цахимаар сургалт зохион байгуулж тусгаарлах байранд дэмжлэгт хяналт хийн арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

ТТӨ-ний талаар албан байгууллагуудад зориулсан 3 төрлийн 160 ширхэг, иргэдэд чиглэсэн 10 төрлийн 250 ширхэг сургалт сурталчилгааны материал боловсруулсан. Цахим орчинд 9 төрлийн 25 удаагийн мэдээ мэдээллийг байршуулсан.

Дэмжлэгт хяналтын ажлын хэсэг дөрвөн эрүүл мэндийн төвийн 102 эмч эмнэлгийн мэргэжилтэнд 2020 оны 482 тоот тушаал, төлөвлөгөө, хариу арга хэмжээний талаар давтан сургалтыг зохион байгууллаа.

Коронавируст халдварын тархалтын 14 дэхь үе шатны үнэлгээг аймаг сумдын хэмжээнд хийж, зөвлөмжийг онцгой комисст танилцуулаад байна

Гепатитгүй Монгол төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн хүн амыг вируст гепатитын халдвараас сэргийлэх, оношлох, эмчлэх зорилготой FIRE төрийн бус байгууллагаас 600 орчим сая төгрөгний санхүүгийн дэмжлэгтэй төсөл орон нутагт хэрэгжиж эрүүл мэндийн байгууллагын 25 эмч ажилчид, 80 элэгний хөтөчийг бэлтгээд байна.

Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс зохион байгуулсан “Коронавируст халдварын үед яаралтай тусламж үзүүлэх нь” зүүн бүсийн сургалтанд 40 эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 40 ЕБС, цэцэрлэгийн эмч, багш, жолооч нарыг хамруулсан.

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлыг зохион байгуулж 3 байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгалаа.

Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны талаар: 2021 оны 08-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 723 иргэнээс эмэгтэй 333, бүртгэлтэй ажилгүй иргэн 541 иргэнээс, эмэгтэй 248 иргэн байна. 354 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 317 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 186 нь байнгын ажлын байртай болсон байна. Шинээр бий болсон 198 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Шинээр ажил хайгчаар 24 иргэнийг бүртгэж програмд шивж ажилласан мөн ажил хайгчийн бүртгэл нь унахаар 150 иргэнтэй утсаар холбогдож ажил хайгчийн бүртгэлийг сэргээсэн. Одоогоор Lmis програмд бүртгэлтэй 687 ажил хайгчаас эрэгтэй 383, Эмэгтэй 304 иргэн байна.

Орон нутгийн бүтээн байгуулалтанд оролцох “Баганат орд”ХХК, “ТЭТҮ” ХХК, “Ханан салхит”ХХК, “Талын зам зэрэг” ТӨХК, зэрэг 4 байгууллагатай гэрээ байгуулж дэмжих бичиг өгч ажиллав. Тухайн байгууллагууд нь шалгарсан тохиолдолд ажил хайгчаар бүртгэлтэй 20 иргэдийг байнгын болон түр ажлын байраар хангаж ажиллана.

ХЗЗ-н эрэлт, нийлүүлэлтийн судалгааг зохион байгуулахтай холбоотойгоор сургалтын бэлтгэл ажил, сумдад ажиллах судалгааны багийн бэлтгэл ажлыг эхлүүлэх, судалгааны багийн санхүүжилт авах зэрэг ажлуудыг судалгааны зөвлөхөөс зөвлөгөө авч бэлтгэн ажиллаж байна.

Монгол улсын засгийн газрын шийдвэрээр 18-34 насны, сүүлийн 3 сар ажил, хөдөлмөр эрхлээгүй, их дээд сургууль болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцдаггүй ЗАЛУУС-ыг хөдөлмөрт бэлтгэх зорилгоор "ОРОЛЦОО" төслийг хэрэгжүүлэхээр болж бүртгэлийг 8 сарын 17 –ны өдрөөс эхлэн .8 сарын 22 ныг хүртэл Е-Монголиа аппелкейшинд нийт 66 залуучуудыг бүртгэв. Үүнд Баруун-урт сум 59, Сумын 7 хүнийг бүртгэлд хамруулж мэдээллийг хүргэж мөн SSB телевизэд ярилцлага өгч ажилласан.

Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар: 2021 оны 08-р сард 13 сумын 54 иргэний нийгмийн халамжийн тэтгэмж, 37 иргэний ахмадын хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтийн 9 хувийн хэргийг хүлээн авч нийгмийн халамжийн Wais программд баталгаажуулсан. E-halamj програмд хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэврийн 38, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн 98, жирэмсэн эхийн 70, ихэр хүүхдийн тэтгэмж 1,онцгой тохиолдлын тэтгэмжийн 2 үйлчилгээг хүлээн авч хянан баталгаажуулсан. Сумдын мэргэжилтнүүдээс тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлт тусламж авах 71 иргэний жагсаалтыг баталгаажуулан авч / W AIS,E-halamj / программд баталгаажуулан нөхөн олголт хийсэн.

2021 оны 08 дугаар сард олгох 1152 иргэний 138386,9 мянган төгрөгийн тэтгэмж , 23 иргэний 3450,0 мянган төгрөгийн ахмадын хөнгөлөлт, 187 иргэний 5548,2 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтийн жагсаалтыг тулган Хаан, Төрийн банкуу илгээсэн. "E-halamj" цахим системээр олгогдох 1260 иргэний 352477,2 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний болон ахмад настны тэтгэврийн, 520 иргэний 20043,9 мянган төгрөгийн жирэмсэн эхийн тэтгэмж, 3171 иргэний 155225,8 мянган төгрөгийн 0-3 хүртэлх

насны хүүхэд асарсны тэтгэмж,1 иргэний ихэр хүүхдийн тэтгэмж, 2 иргэний онцгой тохиолдлын жагсаалтыг тулган баталгаажуулж төрийн сан илгээсэн.

Сумдын АДЗ-өөр хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс түдгэлзүүлэхээр шийдвэрлэгдсэн 24 өрхийн хурлын тэмдэглэлийг ХХҮГ дарга, хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн нартай хэлэлцэж 23 өрх, Баруун-Урт сумын 41 өрхүүдэд зочилж нөхцөл байдлын үнэлгээ хийн ажлын хэсэг хэлэлцэж 32 өрх, нийт 57 өрхийн 248 иргэний үйлчилгээг түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 08 сард 3 удаа хуралдаж 25 хүүхэд орж, 7 хүүхэд асаргаанд шинээр хамрагдаж, 18 хүүхэд асаргаа сунгагдасан байна.

Сүхбаатар аймгийн эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын 4 удаагийн комиссын хурлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын дагуу “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс”-н бүрэлдэхүүнд ажиллаж цагдаагийн газрын дэргэдэх түр хамгаалах байр, Гангын 20 айлын орон сууцны барилга, Даймонд хотхоны 3, 4 дугаар ээлжийн орон сууцны барилгыг хүлээн авсан.

Дөрөв. Хууль, эрх зүйн чиглэлээр:

Хууль, эрх зүй: Аймгийн ЗДТГ-ын даргаар ажиллаж байсан Ч. Энхцэцэгийн нэхэмжлэлтэй Захиргааны хэрэгт нотлох баримт гарган Нийслэл дэх захиргааний хэргийн анхан шатны шүүхэд явуулсан байна.

Төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, үйлчилгээг сайжруулах зорилтын хүрээнд Улсын бүртгэлийн хэлтэст гэрэгэ киоск машин авахад зориулж орон нутгаас 3.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Коронавируст халдвар /Ковид 19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор явуулж буй дээрх арга хэмжээ нь хүний эрхийн зөрчлөөс ангид байх талаар аймгийн Засаг дарга М.Идэрбат эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудад ХЭҮК-оос ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд чиглэл хүргүүллээ.

Сумдын эрх бүхий албан тушаалтан, нотариатын үүрэг гүйцэтгэгч нарт цаг үеийн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаж байна.

Цагдаагийн газар: Аймгийн Шуурхай штабын “Тандалт судалгааны баг”-т тус газрын 1 алба хаагч ажиллаж, батлагдсан тохиолдлуудын ойрын хавьтал 1065, дам хавьтал 434 иргэний судалгааг гарган, явсан маршрут, хаяг байршлыг тогтоон “Хариу арга хэмжээний баг”-т шилжүүлсэн ба цаашид хавьтал тогтоох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Улс, аймгийн Онцгой комиссоос гаргасан дээрх шийдвэрийн дагуу аймаг, сумдаас гарах, орох хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор баталгаат 12, баталгаат бус 8, нийт 20 хяналтын постод цагдаагийн 10, бусад байгууллагын 35, нийт 45 ажилтан, алба хаагч, 4 автомашинтай үүрэг гүйцэтгэж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан төлөвлөгөөний дагуу “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл” урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг “Ирээдүйгээ хамгаалъя” уриатайгаар зохион байгуулж байгаатай холбогдуулан тус цагдаагийн газраас “Та бүсээ заавал бүслээрэй”, “Хүн тээвэр хэтрүүлэхгүй байх”, “Мотоцикл, мопед жолоодохдоо хамгаалах малгайг зааврын дагуу өмсөж хэрэглэх”, “Та хурдаа тохируулж замын хөдөлгөөнд оролцоорой”, “Шөнийн цагт гэрлээ шилжүүлж байх” сэдэвт санамж, сэрэмжлүүлгийг 800 ширхгийг хэвлүүлэн замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч, зорчигч нарт тараан санамж, сэрэмжлүүлгийг танилцуулж түгээсэн.

Албан журмын даатгагчдын нэгдсэн холбоотой хамтран хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн төвийн сурталчилгааны самбарт “Ирээдүйгээ хамгаалъя” сэрэмжлүүлэг бүхий анносыг байрлуулсан.

“Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл 2021” арга хэмжээний хүрээнд хийсэн ажил арга хэмжээний талаар орон нутгийн BBS телевизээр мэдээлэл хийж, иргэд олон нийтэд сурталчилсан.

“Авто замын эвдрэл, тэмдэг тэмдэглэлийн бүрэн бүтэн байдал” арга хэмжээний хүрээнд Баруун-Урт сумын хэмжээнд одоо байгаа 420 ширхэг тэмдгийн бүрэн бүтэн байдал, стандарт, шаардлага хангаж байгаа эсэхэд мэргэжлийн байгууллагын хамт тооллогыг зохион байгуулж ажилласан.

“Авто зогсоол” арга хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн гаднах зогсоол талбайг камержуулах, тэмдэг тэмдэглэл хийх чиглэлээр хариуцсан албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Амралт аяллын өдрүүдтэй холбоотойгоор “Үер усны аюул”, “Зам тээврийн осол”-оос урьдчилан сэргийлэх зорилгоор 4 төрлийн зурагт хуудас хийлгэн Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газар пэйж хуудаст байршуулан 13 сумдын 25 группэд түгээн иргэдэд хүргэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсээс ирүүлсэн 8 төрлийн шторкыг 13 сумын 25 группүүдэд түгээн орон нутгийн BBS телевизээр өдрийн 2 удаагийн давтамжтай нэвтрүүлж иргэдэд хүргэсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: 08 дугаар сарын байдлаар хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний 68 ялтан, этгээдүүдэд холбогдох материалд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулсан. Үүнд:

Торгох ялаар шийтгүүлсэн урьд оны үлдэгдэл 14 ялтны 53400,0 төгрөгийн материал дээр шүүхийн шинээр 90 ялтны 69510.0 төгрөгийн шийтгэх тогтоол хүлээн авч, 94 ялтны 91560.0 төгрөгийн ялын биелэлтийг хангаж, 10 ялтны 31350.0 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нийтэд тустай ажил хийлгэх ялын урьд оны үлдэгдэл 1 ялтны материал дээр шүүхээс шинээр ирсэн 8 ялтны 1820 цагийн ялын материалыг хүлээн авч, 1 ялтны 240 цагийг хорих ялаар солиулж, 3 ялтны 600 цагийн ялын хугацаа дуусаж, үлдэгдэл 4 ялтны 908 цагийн ялыг өршөөлд хамруулсан.

Эрх хасах ялын урьд оны 25 ялтны 11729 хоногийн үлдэгдэл дээр 15 ялтны 125380 хоногийн материал нэмэгдэж, 2 ялтны 3650 хоног үндсэн ялаа эдэлж дууссан үндэслэлээр нэмэгдэж, 1 ялтны 196 хоногийн материалыг хорих ял эдэлж байгаа үндэслэлээр хасаж, 9 ялтныг өршөөлд хамруулж, үлдэгдэл 20 ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээ авагдсан урьд оны үлдэгдэл 5 этгээдийн 19764,0 төгрөг материал дээр шүүхээс шинээр 12 этгээдэд холбогдох 28039,5 төгрөгөөс 14 этгээдийн 21374,8 төгрөгийн хөрөнгө орлогын хураасан авч орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.

Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр 08 дугаар сарын байдлаар нийт 99 хүн, хуулийн этгээдэд холбогдох 65317,7 төгрөгийн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас 84 хүн хуулийн этгээдийн 35392,7 төгрөгийг бүрэн биелүүлж, 15 хүн хуулийн этгээдэд холбогдох 29925,0 төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд бодит биелэлт 95,9 хувьтай байна.

08 дугаар сард Монгол Улсын Өршөөлийн хуулиар суллагдаж зорчих эрхийг хязгаарлах ялаар солигдсон 18 этгээдэд тавих хяналтын ажиллагааг хийж байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр: Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр нийт 518 гүйцэтгэх баримт бичгээс: төлбөрийн биелүүлбэл зохих 294 гүйцэтгэх баримт бичгийн 2084565.5 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж 170 гүйцэтгэх баримт бичгийн 375820.8 мянган төгрөгийн материалыг дуусгавар болгож, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 62.2 хувьтай байна. Бодит биелэлт урьд оны мөн үеэс 11,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Урьд оны мөн үетэй харьцуулахад гүйцэтгэх баримт бичгийн биелэлт 11.3 хувиар, мөнгөн дүнгийн бодит биелэлт 13.8 хувиар тус тус өссөн. Хүүхдийн тэтгэлгийн 240 гүйцэтгэх баримт бичгийн 433156.3 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, хэсэгчлэн 168 гүйцэтгэх баримт бичгийн 213620.4 мянган төгрөгийг төлүүлж, 16 гүйцэтгэх баримт бичгийн 255018.9 мянган төгрөгийг дуусгавар болгон нийт 468639.3 мянган төгрөгийг биелүүлсэн ажилласан. Үлдэгдэл 224 гүйцэтгэх хуудасны 43316.3 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байна.

Шүүхийн шинжилгээний алба: Цагдаагийн газрын шуурхай албаны бүрэлдэхүүнтэй хамтран хэргийн газрын үзлэгт 17 удаа оролцоноос хүний амь нас хохирсон хэргийн дуудлаганд 6, хулгайн хэргийн дуудлагад 4 удаа, зам тээврийн осол хэргийн дуудлагад 6, бусад дуудлагад 1 удаа явж, хэргийн газрын үзлэгээр гарын мөр 11, тээврийн хэрэгслийн мөр 10 ширхэг, бусад ул мөр, эд мөрийн баримт 242 ширхэг, нийт 263 ул мөр илрүүлж, бэхжүүлэн хураан авсан байна.

8-р сарын байдлаар хэргийн газрын үзлэгийн 238 кадр, шинжилгээний 45 кадр, цогцосны үзлэг, задлан шинжилгээний 74 кадр, нийт 357 кадр гэрэл зургийг боловруулж, гэрэл зургийн үзүүлэлт хийж мөрдөгч нарт хүлээлгэн өгсөн.

Криминалистикийн шинжээч нар нь гарын мөрний 3 шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна.

Тус албаны шинжээч эмч нар нь хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 45 удаа хийснээс хүнд 2, хүндэвтэр 2, хөнгөн 13, гэмтлийн зэрэгт хамаарахгүй 10, гэмтлийн зэрэг тогтоогдоогүй 18 дүгнэлт гаргасан байна. Бэлгийн маргаантай хэргийн үзлэг 4 хийж дүгнэлт гаргасан. Гэмт хэргийн болон бусад шалтгаанаар нас барсан 6 цогцост шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан. Шинжээч эмч нар нь химийн 13 шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна.

Улсын бүртгэлийн хэлтэс: Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо-370, анхны бүртгэл-42, өмчлөх эрх шилжих гэрээ-9, барьцааны гэрээ-238, бүртгэлд өөрчлөлт оруулах -13, лавлагаа хуулбар-0, нийт бичигдсэн гэрчилгээний тоо-121

Газар өмчлөх, эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо-258, анхны бүртгэл-12, өмчлөх эрх шилжих гэрээ-57, барьцааны гэрээ-164, бүртгэлд өөрчлөлт оруулах -19, лавлагаа хуулбар-0 нийт бичигдсэн гэрчилгээний тоо-88

Хуулийн этгээдийн улсын бүртгэл: 08 дугаар сарын байдлаар улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоо 10 Үүнээс ХХК-9, төрийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -1 бүртгэгдээд байна. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн-0, татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд-0, үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин бүртгэсэн-0, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт - 5, хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналт лавлагаа олгосон -0, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг 0 –г тус тус бүртгэн хурааж авсан байна.

Иргэний бүртгэл: 08 дугаар сарын байдлаар нийт 137 төрөлт, гэрлэлт 24, гэрлэлт цуцлалт 02, үрчлэлт 2, эцэг тогтоолт 15, овог нэр өөрчлөлт 9, нас баралт 26, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 87, үндэсний энгийн гадаад паспорт 0, шинээр олгосон иргэний цахим үнэмлэх 53, иргэн, аж ахуй нэгжид олгосон лавлагаа 235 тус тус бүртгэж олгосон байна.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлт

Зам тээврийн салбарт: 2019-2021 онд улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа аймгийн төвийн 4 дүгээр тойргийн 9,1 км авто зам, 5 дугаар тойргийн 5,65 км авто зам, Баруун-Урт сумын 1-р багт баригдах 3,03км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн ажлуудын ажлын явц гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдах аймгийн төвийн 2 дугаар тойргийн хатуу хучилттай авто замын засвар, шинэчлэлтийн СБАОНӨГ/202101008 дугаартай гэрээт ажлыг эхлүүлээд байна.

Баруун-Урт сумын 1, 3-р багт хийгдэх авто замын дагуух явган зам, гэрэлтүүлгийн ажлуудын гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.

Уул уурхайн салбарт: Аймгийн Засаг даргын 2021 оны А/149 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын хүрээнд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Сунхунголд”, “Хунт-Өгөөж”, “Премиум көүл”, “Олгой булаг”, “Дорнын чулуулаг” ХХК-иудтай орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний хэлцлийг зохион байгуулж, улмаар гэрээ байгуулах, баталгаажуулалтын ажил хийгдэж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/490, А/491 дүгээр захирамжаар “Сунхунголд”, “Премиум көүл”, “Андын Илч”, “Олгой булаг” ХХК-иудын нүүрс, жонш тээвэрлэлтийн чиглэл түр тогтоосон хугацааг 2021 оны 11 дүгээр сарын 30-ныг дуустал сунгасан.

Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын чиглэлээр: Баяндэлгэр суманд 3 байршлын газар эзэмших эрхийн дуудлага худалдаа зарлан зохион байгуулж, аймгийн төсөвт 2,9 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн. 8 дугаар сарын 18, 19, 20-ний өдрүүдэд Сүхбаатар суманд ажиллаж 55 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 36,0 сая төгрөгийн газрын төлбөрийн нэхэмжлэх хүргүүлсэн. Мөн эзэмшил газраа гэрээнд заасан зориулалтын 2 жил дараалан ашиглаагүй, газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй газруудын судалгааг гарган, газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох захирамжийн төсөл бэлтгэж, сумын засаг даргад танилцуулсан.

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх хээрийн судалгааны ажлыг 08 дугаар сарын 01-15-ны хугацаанд 13 сумын хэмжээнд гүйцэтгэж бэлчээрийн газрын 253 цэгт мониторинг хийж хээрийн судалгааг гүйцэтгэлээ.

Газрын кадастрын мэдээллийн системээр дамжуулан 53 иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажиллаж 19 иргэн хуулийн этгээдийн хүсэлтийг аймгийн Засаг даргад уламжлан 41 шийдвэр / захирамж, нотириат/-ийн бүртгэлийг бүртгэн баталгаажуулж гэрээ, гэрчилгээ, кадастрын зургаар үйлчилсэн байна.

Барилгын тухай хууль болон Засгийн газрын 317 дугаар тогтоолын дагуу улсын комиссын бүрэлдэхүүнийг зохион байгуулах ажлын хүрээнд 2 барилга байгууламжийг үүрэг даалгаврын биелэлтээр 8 сард ашиглалтад оруулсан.

Улсын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламж болох Баруун-Урт сумын 960 хүүхдийн сургууль, шугам сүлжээний ажиллууд, Ариутгалын пункт, Орон сууцны барилгуулын дээврийн их засвар зэрэг барилгуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээ.

Баяндэлгэр сумын 300 хүний суудалтай соёлын төвийн зургийн зохиогчийн хяналтын гэрээний төслийг хүргүүлэн ажилласан.

Аймгийн нутаг дэвсгэрт баригдах барилга байгууламжийг батлагдсан зургийн дагуу, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм нормативыг мөрдүүлж ажиллах, ажлын

зургийн хянан баталгаажуулалт хийх, заавар зөвлөмжийг холбогдох аж ахуй нэгж байгууллагуудад хүргүүлэн ажиллаа.

Ногоон байгууламжийн чиглэлээр: Аймгийн Засаг даргын А/417 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг аймгийн төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэхээр тарьсан модны ургалтын байдлыг тогтоох ажлыг БОАЖГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2021 оны 7-р сарын 23- 26-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв. Ажлын хэсэг төвийн ногоон байгууламжийн усалгаа арчилгааны ажлыг гүйцэтгэгч “Сүхбаатар-Ойжуулалт”, Сум Дундын Ойн Анги,” Ойжуулалт-Хайлааст” ХХК, “ Шаргын модод цэцэрлэг” ХХК, иргэн Д.Баяраа, Ч.Доржхуяг нарын хариуцсан талбайн модны усалгаа, арчилгааг газар дээр нь мод бүрийг үзэж ургалтын байдлыг тогтоов. Нийтийн эзэмшлийн 11 байршил бүхий газарт ургаж байгаа 6 зүйлийн 23385 модонд тооллого хийж ургалтын хувийг тодорхойлоо. Модны амьдралт 89.3%-тай байна. Хэдийгээр модны амьдралт 89.3- тай сайн байгаа боловч ойрын өдрүүдэд хур тунадасгүй хуурайшилт ихтэй байгаа учир усалгааны давтамжийг ойртуулж усалгааг чанартай гүйцэтгэх зөвлөмж, мониторингийн дүгнэлтийг ААН-д хүргүүлж ажиллалаа.

Аймгийн ЗДТГ, БОАЖГ-аас "Сүхбаатар-Ойжуулалт" Сум дундын ойн ангид мод усалгааны машиныг гардуулж өгөв. Энэ жил ойжуулалт, мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэдэг ААНБ-ыг чадвахижуулах, техник шинэчлэлтийг хийж ажлын үр дүнг сайжруулах ажлын хүрээнд техникийн шинэчлэлийг хийж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах чиглэлээр: Төлөвлөгөөний дагуу “Улсын тусгай хамгаалалттай газарт тэмдэгжүүлэлт хийх ажлын”–ын тендерийг зарлаж, уг тендерт Ивээлт есөнжин ХХК шалгарч ТХГН-ийн хилийн багана 6, хаалга 2, Том самбар 2, мэдээллийн самбар шинээр 4, засварласан 2, замын тэмдэг 12 тус хийж одоогийн байдлаар Сүхбаатар сум Дархан Хаан уул, Мөнххаан сум Баянцагааны тал, Дарьганга сум Бичигтийн шахаа, Онгон таван булан зэрэг газруудад хийж байршуулаад байна.

Усны нөөцийг хамгаалах чиглэлээр : Төлөвлөгөөний дагуу аймгийн хэмжээнд 4 суманд 4 булаг хашиж хамгаалах ажлыг зохион байгуулав. Үүнд: Мөнххаан сум Цагаан булаг- /2550,0мян.төг/, Онгон сум Шар бүрд булаг - /10615,0 мян.төг үүнээс 2450,0 мян.төг 2020 онд өгсөн/, Дарьганга сум Салаа булаг - /4000,0 мян.төг/, Наран сум Сөдөтын булаг-/3300,0 мян.төг/, Халзан сум Баянбулаг - /3550,0 мян.төг/ нийт 20 сая төгрөгийг зарцуулаад байна. БХНСАХЗ-аар булаг шанд хашиж хамгаалах хамтран ажиллах гэрээг орон нутагтай байгуулсан. Мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гаргуулах хүсэлт 4 ирсэнээс ирж 3 дүгнэлтийг гаргасан.

Хог хаягдалтай тэмцэх чиглэлээр: Япон сангийн Ядуурлыг бууруулах буцалтгүй тусламж болох 2200.000 \$ санхүүжилтээр Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд хэрэгжиж буй Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжиж эхэллээ. Уг төслийн хүрээнд Баруун-Урт сумаас 4.5 км зайд 8-р багийн нутаг дэвсгэрийн Адгийн шандын 1 га талбайд 53,000м³ хүчин чадал бүхий 2-р зэргийн ландфиллын ажил, хог ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэр, техник тоног төхөөрөмжийн парк шинэчлэлт гэх зэрэг томоохон хөрөнгө оруулалтын ажил 2021-2022 онуудад хэрэгжиж дуусах юм.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг тус төслийн явцтай танилцаж тулгамдаад байсан цахилгааны эх үүсвэр болон техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэхээр болов.

БХНСАХ-ний санхүүжилтээр төвлөрсөн хогийн цэгийн орчимд үүсээд байгаа эзэнгүй хог хаягдлыг түрэх, 10 га газрын 1000 орчим м газрын даланг түрж цэгцлэх ажлыг Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлж байна. Мөн хогийн цэгийг бүтэн тойруулж

гридер татуулж машин орох боломжгүй болгосноор хогийн цэгийн гадна, зам дагуу эзэнгүй үүсэх хог хаягдал цэгцлэгдэх үр дүнтэй ажил болсон .

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажлын хүрээнд Баруун-Урт суманд хөрсөнд нэвчдэггүй эко жорлонг туршилтаар 10 айлд суурилуулах ажлыг хийж байна. Жорлонгийн суурийн ажлыг БОАЖГ-аас гүйцэтгэж байгаа бөгөөд иргэд өөрсдөө бүхээгийг хийж байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны чиглэлээр: Согтууруулах ундаа худалдах зөвшөөрөл сунгуулах хүсэлт гаргасан 1 аж ахуй нэгжийн хүсэлтийг аймгийн Засаг даргын 2021 оны 08 сарын 30-ны өдрийн А/504 дугаар захирамжаар шийдвэрлэсэн байна.

Хөдөө аж ахуй: 2021 оны ноосны урамшуулалд хамрагдах 13 сумын 5608 малчин өрхийн ноосны урамшууллын падааныг хүлээн авав. 2020 оны ноосны урамшуулал ороогүй данс зөрүүтэй 25 малчин өрхийн материалыг засаж янзлан холбогдох газарт хүргүүлсэн.

Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хадлангийн техникийн бэлэн байдлын судалгааг сумдаас нэгтгэж авч хүргүүлсэн.

Засгийн газрын 221 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд аймгийн Засаг даргын А/454 тоот захирамжаар Аймаг, сумын өвс тэжээлийн аюулгүй нөөцийг Эрдэнэцагаан, Дарьганга, Түмэнцогт, Мөнххаан, Асгат, Сүхбаатар сумаас нөөцлөхөөр иргэн аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан хадланд гаргаад байна.

Бэлчээр усжуулалт, худаг ус шинээр гаргах ажлын явцтай танилцах , хяналт хийх ажлаар Баруун-Урт, Халзан, Мөнххаан, Уулбаян, Түвшинширээ, Түмэнцогт, Баяндэлгэр, Асгат сумдад ажилласан

ЗЗББУХТөслийн 70 хувь, орон нутгийн 30 хувийн санхүүжилтээр 2020 онд мал угаалгын 14 ванн шинээр барьсаныг хүлээн авсан.

МУ-ын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монголын эмэгтэйчүүдийн холбоотой хамтран хэрэгжүүлж буй “Дэмжих бүлэг болон хүний эрхийн сургалтаар туслах малчдыг чадавжуулах нь” төслийн хүрээнд Баяндэлгэр, Түвшинширээ, Эрдэнэцагаан сумдын нийт 30 туслах малчдын мэдээллийг шинэчлэн хүргүүллээ.

Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд “Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 221 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн салбар болон төв суурин газрын 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах тухай аймгийн Засаг даргын албан даалгаврыг баталж, холбогдох газруудад хүргүүллээ.

Мал эмнэлэг: Төл малд бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад тугал-15433, хурга-117323, ишиг-67627 нийт-200383 толгой мал тарилга-30%-тай хийгдээд байна.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад Дарьганга, Уулбаян, Эрдэнэцагаан, Халзан, Баяндэлгэр, Онгон, Наран, Түвшинширээ зэрэг 8 сумын үхэр-199755, хонь-10393828, ямаа-697985, нийт-1937122 толгой малд тарилга 100%-тай хийгдэж дууссан.

Мал сүргийг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Аймгийн Засаг даргын А/220 тоот захирамжийн дагуу угаалганд-2999721 толгой хамрагдахаас үхэр-24324,

хонь-764883, ямаа-415067 нийт-1204274 толгой мал, 45% -тай ванндаж, шүршиж угааж хийгдэж байна.

Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт үхрийн сүрьеэ лейкоз өвчин түүний халдвараар тайван эсэхийг тогтоох түүнийг баталгаажуулах ажлын хүрээнд Түмэнцогт, Мөнххаан, Баруун-Урт, Эрдэнэцагаан сумдын 8 багийн 24 малчин өрхийн 120 толгой үхрийн дээж авлаа. Дээжийг УМЭАЦТЛ -т хүргүүлсэн ба ийлдэс судлалын шинжилгээнд Сүхбаатар, Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Баруун-Урт, Уулбаян сумдаас хээлтүүлэгчийн 119 цус ирж ийлдсэнд Розбенгалийн урвал тавихад эерэг урвал илрээгүй.

Мал эмнэлгийн газрын хяналт шалгалтын ажлын хэсэг МЭТасаг, МЭҮН-ийн 2020 оны ажил үйлчилгээний гүйцэтгэл, 2021 оны төлөвлөлт гүйцэтгэл, шүлхий өвчнөөс сэргийлэх гүйцэтгэлийн хяналт шалгалтаар хоёр удаа явсан. Шалгалтад 12 сумын мал эмнэлгийн тасаг 16 мал эмнэлэг үйлчилгээний нэгж, 20 малчин өрх, 3 малын эмийн сан 1 мал нядалгааны газрын үйл ажиллагаатай танилцаж заавар зөвлөмж өгч, хяналт тавьж ажилласан.

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн эрт илрүүлэгчийн сургалт Мөнххаан, Уулбаян, Баруун-Урт, Дарьганга сумдад амжилттай зохион байгуулагдлаа. Сургалтад 13 сумын 54 мал эмнэлгийн 51 малын эмч 25 мэргэжилтэн хамрагдлаа.

Зургаа. Батлан хамгаалах

Батлах хамгаалахын төв архив, Тагнуулын ерөнхий газрын тусгай архив, Хил хамгаалах ерөнхий газрын хилийн цэргийн төв архивуудад цэргийн алба хаасан тухай архивын лавлагааг хүссэн 11 иргэний хүсэлтийг албан бичгээр гаргуулан олгосон.

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 сарын 19-ны өдрийн А/377 дугаар захирамж, Цэргийн штабын 2021 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийн сургалтыг 14 хоногийн хугацаатай хээрийн байрлалд зохион байгууллаа.

Долоо.Шадар сайдын эрхлэх хүрээний агентлагууд

Мэргэжлийн хяналтын газар: Коронавирусын халдвараар батлагдсан тохиолдлын явсан маршрутын дагуу /өссөн дүнгээр/ нийт 1462 газрын, 85572.5 м.кв талбайд Баяндэлгэр сум, Мөнххаан сум, Түвшинширээ сум, Сүхбаатар сум, Халзан сумдын эрүүл мэндийн төвүүд голомтын эцсийн ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж, Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч хөндлөнгийн хяналт тавьж ажиллалаа.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын баталсан 01/91 дугаартай удирдамжийн дагуу “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын батлагдсан болон сэжигтэй цогцос”-ыг оршуулах үйл ажиллагаанд 4 удаагийн хяналт тавьж, тухайн оршуулга болсон газрын байршлыг координатаар тогтоож, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн ажилласан.

2020-2021 оны хичээлийн жилд тус аймгийн ерөнхий боловсролын 9 сургуулийн 12 дугаар анги төгсөгчдөөс 648 суралцагч элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөөр бүртгүүлсэн бөгөөд давтлаганд 510 сурагч хамрагдаж, 82 анги танхимд мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйтгэл хийлгэж, амны хаалтыг тогтмол хэрэглүүлж, гар ариутгах нөхцөлийг бүрдүүлэн, халдвар хамгааллын дэглэмийн сайтар баримтлан ажилласан.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 01/130 тоот удирдамжийн хүрээнд хичээлийн шинэ жилийн бэлтгэл, бэлэн байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийж, Баруун-Урт сумын сургууль, цэцэрлэгүүдийг

хамрууллаа. Мөн 13 сумын ерөнхий боловсролын 16 сургууль, 24 сургуулийн өмнөх боловсролын байгууллагын захирал, эрхлэгч, сургалтын менежер, эмч, нягтлан, нярав, тогооч зэрэг 120 хүнийг хамруулан “Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан 2021 оны 08 дугаар 19-ний өдрийн А/292, А/525 дугаар тушаалаар батлагдсан түр журам, хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлын үед анхаарах асуудал” сэдвээр цахим сургалтыг зохион байгуулсан.

Цаашид хяналт шалгалтын ажил үргэлжлэн хийгдэх ба 4-өөс доошгүй сумыг хамруулахаар төлөвлөж байна.

2021-2022 оны хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан Баруун-Урт сумын сургууль, цэцэрлэг, дотуур байр, МСҮТөвүүдэд шинжилгээт шалгалтыг хийж байна. Шалгалтын явцад ундны усны 25 дээж авч, Мэргэжлийн хяналтын газрын нэгдсэн лабораторид 325 үзүүлэлтээр шинжилгээнд хамрууллаа.

Мөн хоол үйлдвэрлэл үйлчилгээ болон халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтөд урьдчилан сэргийлэх хяналтыг хийж, зөвлөмж, мэдээллээр ханган ажилласны дүнд сургалтын байгууллагууд халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтийг хангаж, анги, танхимуудад ширээ хоорондын зайг 1.5-2 метрийн зайтай байрлуулан, сэжигтэй тохиолдолд зориулсан “Түр тусгаарлах өрөө” –г байгуулсан байна. Хяналт шалгалт үргэлжилж байна.

Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналт: 2021 оны 01 сарын 02-ноос 2021 оны 08 сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд улсын хилээр нэвтэрсэн нүүрс, татан авалтын тээврийн хэрэгсэл, трактор зэрэг 4233 тээврийн хэрэгсэл, газрын тосны 4455 тээврийн хэрэгсэл буюу өдөрт дунджаар 49-55 тээврийн хэрэгсэл нийт 8688 тээврийн хэрэгсэлд гадаргууг мананцаржуулах болон хуурай аргаар, бүхээгний халдваргүйжүүлэлтийг жавелионы 0.03-0.06%-ийн уусмалаар гадна талаас дотогш, зах хэсгээс төв рүү, дээрээс доошоо гэсэн дарааллаар хийж халдварын эх үүсгэврийг устгах, идэвхгүйжүүлэх арга хэмжээ авч, урьдчилан сэргийлэх болон эцсийн халдваргүйжүүлэлтийг хийн ажиллаж байна.

Сүхбаатар аймгийн Бичигт боомтын орох чиглэлийн замд 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр “Петро чайна дачин тамсаг” ХХК-ийн санхүүжилтээр 25 м-ийн урттай 4.5 м өргөн, 4.5 м-ийн өндрийн хэмжээтэй, хаалгатай, дулааны улиралд ажиллах зориулалт бүхий байгууламжийг барьсан. Одоогийн байдлаар засварын ажил хийгдэж эхэлсэн бөгөөд тээврийн хэрэгслийг хөл ваннд туулуулах аргаар, гадаргуугийн болон кабины дотор тал, бариул зэргийг автомаксаар шүршиж ариутган ариутгал халдваргүйжүүлэлт хийгдэж байна.

МХЕГ-ын даргын 2020 оны А/31 дүгээр тушаалын дагуу 8756 тээврийн хэрэгслийн жолоочдоос “Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг”, “Жолоочийн эрүүл мэндийн хуудас”-аар асуумж авч, зөөврийн термокамер, термометрээр биеийн халууныг хэмжин эрүүл мэндийн тандалт судалгааг өдөр бүр тогтмол хийж хэвшин мэдээллийн сан үүсгэсэн байна.

Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэст /Бичигт боомт/ аюултай хог хаягдлыг устгах 1.8 м х 1.2 м хэмжээтэй шатаах зуух, 2.5 х 3 м хэмжээтэй хамгаалалтын хашаа хийх ажлыг санаачилан боомтын хил, хяналтын байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэсэн.

2021 оны хагас жилийн байдлаар уг шатаах зуухаар хилийн нэвтрэх цэгт үүрэг гүйцэтгэж буй албан хаагчид, тээврийн хэрэгслийн жолоочдын хэрэглэсэн 7633.6 кг нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгслийг ЭМС-ын 2017 оны А/505, 2020 оны А/510 тоот тушаалын дагуу өдөр бүр хамгаалах хувцас, хэрэгслийг шатааж, булж устган халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн ажиллаж байна.

2021 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2021 оны 08 дугаар сарын 20-ыг хүртэлхи хугацаанд **экспортын хяналт шалгалтад:** 8488 тээврийн хэрэгсэл, 8756 зорчигч, 1 аж ахуй нэгжийн 4455 тээврийн хэрэгслээр 137540.8 тн-1099166.4 баррель газрын тос /түүхий/, 10

аж ахуй нэгжийн 3974 тээврийн хэрэгслээр 362533.6 тн хүрэн нүүрс, 1 аж ахуй нэгжийн 12 тээврийн хэрэгслээр 1236.6 тн хайлуур жонш, 3 аж ахуй нэгжийн 47 тээврийн хэрэглээр 5138.4 тн төмрийн хүдэр экспортлогдсон байна.

Импортын хяналт шалгалт: 8688 тээврийн хэрэгсэл, ачигдаж ирсэн 25 пад трактор, 8756 зорчигч, 4 аж ахуйн нэгжийн 1010.2 тн полистирол, 15 аж ахуйн нэгжийн 30 нэр төрлийн 737.8 тн барилгын материал, 1 аж ахуйн нэгжийн 13 ширхэг лифт, 1 аж ахуйн нэгжийн 8 нэр төрлийн 8.0 тн ахуйн бараа, 1 аж ахуйн нэгжийн 14 ширхэг хүлэмж, 1 аж ахуйн нэгжийн 2 сэт сууц, 1 аж ахуйн нэгжийн 3.0 тн-ын ёмкость 3 ширхэг, 5.0 тн-ын ёмкость 2 ширхэг зэрэг бараа бүтээгдэхүүн тус тус хяналт шалгалтанд хамрагдсан ба ариутгал халдваргүйжүүлэлтанд хамрагдсан. Мөн татан авалтын 1 ширхэг цахилгаан үүсгүүр, 1 ширхэг тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл болон 109 тээврийн хэрэгсэл, 152 трактор, 6 ковш, 3 бага оврын автобус болон хадлангийн 77 ширхэг хадуур, 35 ширхэг тармуур, 4 ширхэг өвс пресслэгч хяналт шалгалтад хамрагдсан болно.

Онцгой байдлын газар:

Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар: Баруун-Урт сумын хэмжээнд Гамшгаас хамгаалах дайчилгааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг томилон Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу аймгийн хэмжээнд 58 аж ахуйн нэгж байгууллагын Коронавирус "COVID-19"-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, цар тахалтай тэмцэх хүч хэрэгслийн бэлэн байдлыг дээшлүүлэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд мэргэжлийн ангийг дайчлах, хүн хүч, техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж бэлэн байдлын үзлэгт 18 мэргэжлийн ангийн 110 техник хэрэгсэл, 263 хүн хамрагдсан байна. Аймгийн Онцгой комиссын 25 дугаар хуралдаан, Шуурхай штабын тохиолдлын удирдлагын тогтолцооны баг бүлгүүд өдөр болгоны 10:00 цагт хуралдаж, мэдээлэл солилцон тулгамдсан асуудлыг шийдэж, УОК-ын 42, 43, 46 дугаар тушаалаар баталсан журмыг удирдлагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна. Шуурхай штаб-д: Онцгой байдлын газраас 7 алба хаагч, Нийгмийн даатгал: 1, Мэргэжлийн хяналтын газраас:3, Автотээвэр: 4 удаа, өдрөөр 48 цаг, ЭМГазар: 2 удаа, үүргийг тус тус гүйцэтгэсэн.

Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээний чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/188 дугаар тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу “Кило майн” ХХК Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын нутаг дэвсгэрт байрлах Говь мастер ХХК-ийн Хайлуур жоншны орд “Базальт”-ын уурхайн олборлолт хийсэн гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланд анхан шатны шинжилгээ хийж ажилласан.

Хяналт шалгалтын талаар: Аж ахуйн нэгж байгууллага хүсэлт өгсний дагуу нийт 20 барилга байгууламжид хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, гал гарч болзошгүй 68 зөрчил илрүүлэн газар дээр нь 34 зөрчлийг арилгуулж бусад зөрчлийг арилгуулахаар заавал биелүүлэх албан шаардлага 6, мэдэгдэл 2, дүгнэлт 3-ийг тус тус үйлдэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Мөн ажилчдад Галын аюулгүй байдлын тухай хууль, аж ахуйн нэгж, байгууллагын галын аюулгүй байдлыг хангах чиглэлээр танхимын сургалт болон гал унтраагуур ажиллуулах талаар дадлага сургуулийг 16 ажилчныг хамруулан зохион явууллаа. Шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар заавар зөвлөмж өгч ажилтан алба хаагч нарын мэдвэл зохих хууль, дүрэм, гал унтраах багаж хэрэгслийг ажиллуулах заавар, зэргийг гарын авлага материалыг боловсруулан хүргүүлэн ажиллаж ирлээ.

2021 оны 08 дугаар сард ОБЕГ-ын даргын 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан А/02 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Галын аюулгүй байдал нь хангагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 6-ыг гаргаж 75000 төгрөг, 3 барилгын зураг хянаж 150000 төгрөг, нийт 225000 төгрөгийг аймгийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлэн ажиллалаа.

Гал түймэртэй тэмцэх, унтраах үйл ажиллагааны чиглэлээр: Гал түймэр унтраах, аврах 15 дугаар анги нь томилгоот харуул ээлжинд 31-н удаагийн 744 цагийн үүрэг гүйцэтгэлээ. Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хэмжээнд 2021 оны 07 дугаар сард объектын гал түймрийн дуудлагаар 1-н удаа унтраах, аврах ажлыг зохион байгуулж, ард иргэдийн 20 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалж, тактикийн алдаа дутагдалгүй, техникийн сааталгүй ажилласан.

Найм. Сумдад зохион байгуулагдсан ажил

Баруун-урт:

Ногоон байгууламж, дэд бүтэц, хог хаягдлын чиглэлээр: Шарилж устгалын ажлын чиглэлээр Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран нийтийг хамарсан ажилд 10 иргэнийг түр ажлын байраар хангаж 10 өдрийн хугацаанд 13000 мк талбайг цэвэрлэсэн байна.

Ногоон байгууламжийг хариуцан гүйцэтгэх ОНӨААТҮГ-аар шинээр байгуулагдсан.

Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр Японы ядуурлыг бууруулах сангийн төслөөр нэгдсэн хогийн цэгт тохижилтын ажил хийгдэж байна

Нүхэн жорлонг ариутгагч Тамир био бэлдмэлийг 9 багийн 300 өрхөд хүлээлгэн өгч ариутгалын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/297 дугаар захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд боловсон жорлон хийх төслийг хэрэгжүүлж нийт 10 өрхөд байршуулаад байна.

Ногоон байгууламжийг хашиж хамгаалах ажлыг 2000 мкв талбайд хийсэн.

Багуудын гэр хорооллын цамхагт гэрэлтүүлэг байршуулах ажлыг Уртын гэгээ ОНӨААТҮГ-ийг гүйцэтгэж байна.

Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр: Махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн 14 бяруун бухыг малчдад түрээсийн гэрээгээр олгож малын чанарыг сайжруулах бодлого барин ажиллаж байна.

Сумын хэмжээнд худалдаа үйлчилгээний 25 кароеке баар, 77 дэлгүүртэй нийт 107 аж нэгж байгууллагуудтай Хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын А/119 тоот захирамжийн дагуу малын шоц халдварт паразит дах өвчнөөс урьдчилан сэргийлэх мал угаалгын ажилд үхэр 542, хонь 104429, ямаа 52795, тус бүр хамрагдаад байна.

Сум хөгжүүлэх сан: Сум дундын иргэний анхан шатны шүүхэд дэх эвлэрлийн жуулчлалт шилжүүлсэн нэхэмжлэлийн дагуу 6 иргэний 4,8 сая төгрөг хугацаа хэтэрсэн 2 иргэний 4,3 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сан: Орон нутаг хөгжүүлэх сангийн удирдлага мэдээллийн сангийн хуваарлалт төлөвлөлт хэрэгжилт цэсэнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээний мэдээллийг тухай бүр оруулж танилцуулсан Тус сангаас хийгдэж буй бүтээн байгуулалт сумын Засаг даргын А/175 дугаар захирамжаар байгуулж удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг хийж орон нутгийн BBS ТЕЛЕВИЗТЭЙ хамтран ажилласан.

Төрийн сан: 8 дугаар сарын байдлаар орон нутгийн болон харьяа төсөвт байгууллагуудын 10 285 905 мянган төгрөгний /4692/ мөнгөн зарлагын гүйлгээнд хяналт тавин баталгаажуулсан.

Төрийн санд 1 101 244 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлого орж, татварын орлогын төлөвлөгөө 113 хувьтай биелсэн.

Коронавирусээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд: Тусгаарлах 3 байрыг бэлэн байлгаж эмч ажилчдад 5 удаа 1 удаагийн иж бүрэн хамгаалах хувцасаар

хангасан. Татан авалтанд 29 байгууллагын жолооч машиныг татан ажилуулж тайлант хугацаанд 83 хүн тусгаарлах байранд тусгаарлагдаж, 78 хүн эдгэрч эмнэлгээс гарсан.

Дарьганга:

Төрийн удирдлагын чиглэлээр: Сумын ИТХ-ээлжит хуралдаанаар Төсвийн тодотгол хийж, Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголоор хадлангийн 1500 га, дэд бүтцийн хүрээнд уурын зуухны барилга барих 1000 га талбайг тус тус хэлэлцэн шийдвэрлэв.

ОНХС-ийн хөрөнгөөр (19895000 төг)-өөр хийгдэх хүүхдийн тоглоомын талбайн гүйцэтгэгчээр иргэнийг томилж, санхүүжилтийг олголоо.

ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хийгдсэн ажлын үр дүнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгах чиглэлээр сумын Засаг даргын захирамж гарч, бүртгэл хөтлөлтийг хийж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын тухай хуулийн төсөлд сумын төрийн байгууллагуудын удирдлагаас санал хүсэлтийг авч, нэгтгэн хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2021.08.11 ний өдрийн 1/749 тоот албан бичгийн дагуу Сүхбаатар аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг 6 чиглэлээр авч, мэдээг хүргүүлэх зорилготой холбогдох албан хаагчдад үүрэг өгч ажилласан.

Сумын Засаг даргын дэргэдэх “Орон тооны бус зөвлөл”-ийн хурлаар хориотой ангийн зөрчлөөр илрүүлсэн нэг тарвагыг улсын орлого болгох буюу устгах асуудлыг хэлэлцэн, сумын Устгалын комисст шилжүүлсэн.

Удирдлагын академийн “Уул уурхайн компаниудын үйл ажиллагааг нийгэм хүлээн зөвшөөрөх байдал”-д судалгаа хийх санал асуулгад сумын ЗДТГ-аас оролцож санал хүргүүлээ.

Төрийн үйлчилгээний оператор систем www.operator.e-mongolia.mn үзүүлсэн үйлчилгээний тайлан

Д/д	Үйлчилгээний тоо			Хамгийн их үзүүлсэн 10 үйлчилгээ	
	Нийт	Төлбөртэй	Төлбөргүй	Нэр	Тоо
	0	0	Төлбөргүй	Иргэний үнэмлэхний лавлагаа	13
2.	0	0	Төлбөргүй	Оршин суугаа хаягийн тодорхойлолт	1
3.	0		Төлбөргүй	Жолоочийн лавлагаа мэдээлэл	4
4.	2.000	1.000төгрөг		Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт	2
5.	2.000	2.000төгрөг		Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт	1
6.	0	0	Төлбөргүй	Үл хөдлөх хөрөнгийн жагсаалт	2
7.	0	0	Төлбөргүй	Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа	1

8.	0	0	Төлбөргүй	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл	8
Нийт					32

Хөдөө аж ахуйн чиглэлээр.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 44, 45 дугаар тогтоолын дагуу хонь, тэмээний ноос бэлтгэж, хоршоогоор дамжуулан үндэсний үйлдвэрт тушаасан 334 малчин, мал бүхий иргэдийн падааныг хүлээн авч нэгтгэн программд оруулан аймгийн ХХААГ-т падааныг жагсаалтын дагуу хүлээлгэн өгсөн.

Баянцагаан, Богдын шар өндөр, Өндөр хүрээт гэсэн газаруудад хадлангийн 10 салаа гарах бэлтгэл хангагдаад байгаа бөгөөд хадланчдын мэдээллийг аймгийн ХХААГ-т явуулсан.

Газар тариалангийн чиглэлээр 9 иргэн үйл ажиллагаа явуулж, хүнсний ногоо тариалж байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр: Сумын Амьжиргааг Дамжих Зөвлөлийн хурлыг 2 удаа хуралдуулж, асаргааны сунгалт болон хүнсний эрхийн бичгийн баталгаа авч буй өрхүүдийг хэлэлцсэн.

Байгаль орчны чиглэлээр: Аймгийн БОГ-ын дэмжлэг санхүүжилтээр 4 сая төгрөгийн хөрөнгөөр сумын Баянголын гүүрийг засварлах ажил хийгдэж байна.

1000 машины зогсоол бүхий талбайн шарилжийг түүх, өв соёлын дурсгалыг цэвэрлэх зэрэг ажлуудад төрийн албан хаагчид манлайлан оролцлоо.

Эрүүл мэндийн чиглэлээр: УИХ-ын гишүүн Ж. Чинбүрэнгийн дэмжлэгээр 52 сая төгрөгийн санхүүжилтээр “Шүдний иж бүрэн аппарат”-ыг сумын ЭМТ-д хүлээн аваад байна.

Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн мэргэжлийн 5 эмч суманд ажиллаж 140 хүнд шинжилгээ оношилгоо хийсэн.

Цаг үеийн нөхцөлд тулгуурлан аялал жуулчлалын Талын агуйтын баазад 4 жорлон, талбайд ариутгал халдваргүйтгэл хийж, үйлчилгээний 34 ажилтанд түргэвчилсэн тестийн үзлэг хийхэд сөрөг гарсан.

ЕБС, Цэцэрлэгийн үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан цэцэрлэгийн 10 ажилтанд түргэвчилсэн тест тавьж сөрөг гарсан.

Боловсрол, соёлын чиглэлээр: Сургууль, Цэцэрлэгийн гадна доторх засвар үйлчилгээ хийгдэж одоогоор 80 % тай байна.

Мөнххаан:

Төсөв санхүүгийн хүрээнд: 04-ын ЦДАШ –ын зураг төсөв засварын ажлын тендерт Баясалтөгс ХХК шалгарсан.

Сумын ОНХС-ын 2020-2021 оны гүйцэтгэлийн үнэлгээг хийх баг ирж ажиллаж ОНХС-ын гүйцэтгэлд 37 шалгуур үзүүлэлтээр үнэлгээг хийж ажилласан.

08 сарын 16-19 ны хооронд явагдсан авто тээврийн хэрэгслийн улсын үзлэгт 600 гаруй тээврийн хэрэгсэл хамрагдаж аймгийн татварт 10,0 гаруй сая төгрөгийг төвлөрүүлсэн.

СХС-ийн зээлийн төлөгдөөгүй байгаа иргэдийн судалгааг гарган аймгийн прокурорын газарт материалыг хүргүүлж ажилласан.

Нийгмийн бодлогын хүрээнд:

ЕБС: 2021-2022 оны хичээлийн жил эхэлж байгаатай холбогдуулан хичээлийн 1, 2-р байрууд болон дотуур байранд урсгал засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Анги удирдсан багш нар тус тусын анги танхим, кабинетуудын тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал болон шаардлагатай засваруудыг бүрэн хийж хичээл сургалтын үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон.

Тус сумын 5 дугаар багийн Аймгийн сайн малчин А.Мөнхдоржтой хамтран Байгалийн ухааны заах аргын нэгдлийн багш нарын өрөөг шинэчлэн тохижуулсан ба сургуулийн төсвөөр Нийгмийн ухааны заах аргын нэгдлийн багш нарын өрөөг мөн тохижуулж, хуучин багш нарын өрөөг мэдээлэл зүйн кабинет болгон тохижуулах ажлыг эхлүүлээд байна. Хичээл сургалтын үйл ажиллагаа явуулахад анги танхим хүрэлцээ муутай байдагтай холбогдуулан хуучин мэдээлэл зүйн кабинетыг хичээлийн танхим болгон тохижуулсан.

Төгсөх ангийн сурагчдын ЭЕШ-ын давтлагыг хуваарийн дагуу зохион байгуулж энэ сарын 18-22-ны өдрүүдэд Баруун-Урт хотод 12 дугаар ангийн нийт сурагчдыг ЭЕШ-нд бүрэн хамрууллаа. 12-р ангийн сурагч Б.Минжүүрмаа математикийн хичээлээр 723 оноо /аймгийн хэмжээнд 5-р байр/, нийгмийн ухааны хичээлээр 782 оноо /аймгийн хэмжээнд 2-р байр/, сурагч А.Марал монгол хэлний хичээлээр 771 оноо /аймгийн хэмжээнд 3-р байр/, сурагч Ш.Буянхишиг монгол хэлний хичээлээр 701 оноо /аймгийн хэмжээнд 15-р байр/-т жагсаж сумынхаа нийт сурагчдыг тэргүүлэв.

2021 оны ЭЕШ-д тус сургуулийн 38 сурагч 7 хичээлээр шалгалт өгсөн ба сургуулийн дундаж Англи хэлний хичээл 530.1 оноо, Химийн хичээл 510.1 оноо, Нийгмийн тухай мэдлэг хичээл 508.1 оноо, Математикийн хичээл 535.5 оноо, Биологийн хичээл 481.1 оноо, Физикийн хичээл 503.3 оноо, Монгол хэлний хичээл 557.1 оноотой дүгнэгдсэн бөгөөд Англи хэл, Хими, Математик, Физик, Монгол хэлний хичээлүүдээр улс, аймгийн дунджаас дээгүүр, Нийгмийн тухай мэдлэг хичээлээр улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн амжилтыг үзүүллээ. НТМ, Математик, Монгол хэл хичээлүүдээр 4 сурагч 700-с дээш оноотой шалгагдсан.

Эрүүл мэндийн чиглэлээр: 08 сарын 27-ны байдлаар 45өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүнээс дотор -13, халдварт -31, хүүхэд-1 хэвтэн эмчлүүлсэн. Хүнд хүндэвтэр хүн байхгүй.

8 сард хийгдсэн вакцины хамралт Вероцелл 1-р тун 3, 2-р тун 13 хүн, Пфайзер 1-р тун 55, 2-р тун 221 хүн хийлгэсэн. 8 сарын 24-ны байдлаар сумын эмнэлгийн халдвартын 2 өрөө болон 2 гэрт 23 хүн хэвтэн эмчлүүлж, тусгаарлан ажиглах байранд 2 хүн эмчлүүлж байсан.

Сумын Соёлын төвд Ковид19-ын эмнэлэг дэлгэн ажиллуулж өдөөрийн байдлаар 31 хүн хэвтэн эмчлүүлж байна. Мөн энэ хугацаанд 3 ээлжээр 10 эмнэлгийн ажилтан улаан бүсэд ажиллаж байна. Дээрх хугацаанд ойр 256 дам 117 хавьталын хүнийг ажиглалтад авч хянаж байна. Өнөөдрийн байдлаар 85 ойр, дам хавьтал гэрийн тусгаарлалтанд хянагдаж байна. 7 сарын 23-аас 8 сарын 27 хүртэл 157 хүний ПГУ шинжилгээний сорьц цуглуулж АНЭ-т илгээсэн ба түргэвчилсэн шинжилгээ 53 хийсэн.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх оролцоо төслийн бүртгэлд 18-34 насны 6 иргэн хамрагдах саналаа өгч бүртгүүлсэн.

Мал эмнэлгийн болон ХХАА-н чиглэлээр: Зах зээл ба бэлчээр удирдлагын хөгжил төслөөс 75847965 санхүүжилтээр орон нутгийн хөгжүүлэх сангаас 32506280 төгрөгийн санхүүжилтээр Өвс тэжээлийн агуулах саравч барих ажлыг Шарга ХХК хийж гүйцэтгэж байна.

Ноосны урамшуулалд нийт 645 малчин өрхийн падааныг бичиж тушаасан. Сумын Засаг даргын 2021оны 08 дугаар 01-ны өдрийн А/116 тоот захирамжаар суманд 5 групп гарч бруцеллээс өвчнөөс сэргийлэх тарилгад 7380 тугал, 67200 хурга, 45750 ишиг, нийт 120330 төл малыг хамруулах ажил зохион байгуулагдан өнөөдрийн байдлаар 4800 тугал, 42700 хурга, 29380 ишиг, нийт 76880 толгой төл мал хамрагдаж 63,9 хувьтай байна.

2021 онд паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Засаг даргын 2021.07.09-ны өдрийн А/07 тоот захирамжаар 399894 толгой малыг хамруулахаас 245969 толгой малыг угаалганд хамруулан явц 61,5 хувьтай хийгдээд байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан тандалт төлөвлөгөөний УМЭАЦТЛ-ийн захирлын удирдамж арга зүйн дагуу Мөнххаан сумын нутаг дэвсгэрт үхрийн сүрьеэ

лейкоз өвчин түүний халдвараар тайван эсэхийг тогтоох, баталгаажуулах зорилгоор 6 малчин өрхийн 30 толгой үхрээс ийлдсийн дээж авч аймгийн мал эмнэлгийн лабораторид шинжлүүлэхээр хүргүүлээд байна.

Мал эмнэлгийн ерөнхий газар, НҮҮБ-ын ХХААБ-тай хамтран “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд “Мал сүрэгт эрүүл мэндийн үзлэг хийх эрт илрүүлгийг цахим системийг хэрэглэх, эрслийн үнэлгээ хийх” танхимын сургалтыг Мал эмнэлгийн ерөнхий газар, төслийн нэгж, “Дижитал медик” ХХК-наас хамтран зохион байгуулж, Түмэнцогт, Мөнххаан сумдын ХХМЭҮН болон мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч, улсын байцаагч, малын эмч нарыг хамруулсан.

Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр: 8 сарын 9-15 ны өдрүүдэд бэлчээрийн фотомониторингийн цэгийн хээрийн судалгаа хийх ажлаар хөдөөгийн 5 багийн 25 цэг дээр Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн багуудын Засаг дарга нартай хамтран ажилласан.

Төмс хүнсний ногоо усалгаагүй тариалангийн зориулалтаар өрхөд эзэмшүүлэх 20 нэгж талбарын олголтыг хийж дуусган гэрээ хийж гэрчилгээжүүлж дуусгалаа.

Тус сумын нутаг дэвсгэрт /4 байршилд/ нутагшуулсан 61ш тарваганд мониторинг хийж ажилласан.

Наран:

Ерөнхий боловсрол: 1-р ангийн цахим элсэлтийн комиссыг томилж, бүртгэлийг 08-р сарын 16-20-ны дотор хийж, гүйцэтгэлийн хувь 85%-тай байна.

Байгууллагад шаардлагатай 2 багшийн орон тоог олон нийтэд нээлттэй зарласан.

Сургуулийн өмнөх боловсрол: Тухайн хичээлийн жилд хамрагдах 2-5 настай хүүхдийн нарийвчилсан судалгааг гаргаж холбогдох газарт тоо баримтыг хүргүүлэн ажилласан. Мөн 4,5 настай шинээр элсэх хүүхдийн бүртгэлийг хийж байна.

Цэцэрлэгийн гадна талбайд эрсдэлийн үнэлгээг хийсэн. Түүний дагуу орчныг засан сайжруулах ажиллагаа явагдаж байна.

Байгаль орчны чиглэлээр: 1-р багийн нутаг Цөнгөрөг, 2-р багийн нутаг Ноён хөндий, 3-р багийн нутаг Тайгын хөндий зэрэг газруудад бэлчээр талхлалтын явуулын судалгаа хийж, 1, 2-р багийн нутагт 13 цэгт бэлчээрийн фото мониторингийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Залуучуудын хөдөлмөрт бэлтгэх оролцоо төслийн зарыг сумын 2 группт байршуулж 19 иргэнд утсаар мэдээлэл өгч 7 хүнийг бүртгэсэн байна. Ажил зуучлалаар 2 иргэнийг Iims программд бүртгээд байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа хийж асаргаа сунгуулах 3 иргэний асуудлыг хэлэлцсэн.

Сард үйлчилгээ үзүүлж байгаа иргэдээ нас, хүйс, боловсрол, үйлчилгээ авсан төрлөөр нь дэлгэрэнгүй бүртгэл хөтлөн ажиллаж байна. Үүний дагуу 8 сарын 23-ны байдлаар 158 иргэнд 17 чиглэлээр мэдээлэл өгч ажилласан байна.

Улсын бүртгэлийн чиглэлээр: Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл Үүнд: Төрсний бүртгэл -2, Иргэний цахим үнэмлэх олголт-10, Иргэний үнэмлэх захиалга – 8, Лавлагаа гэрчилгээ дахин олголт: Цахим үнэмлэхний лавлагаа албан хэрэгцээнд -5, Гэрлэлтийн лавлагаа- 1, Иргэний шилжилт хөдөлгөөн: Аймаг сумаас шилжиж ирсэн – 1 нийт 27 иргэний бүртгэлийн холбогдох бичиг баримтыг хүлээн авч хүсэлтийн дагуу шийдвэрлэж ИУБ хаадар маягтуудыг Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.

Эрүүл мэндийн чиглэлээр: 12-17 насны 132 хүүхдэд Пфайзер вакцины 1,2-р тун, 18-с дээш насны 5 иргэнд Вероцелл вакцины 2-р тунг хийсэн.

Наран ЭМТ цахим хуудсаар ковид-19 халдвараас сэргийлэх зөвлөмжүүдийг иргэдэд нийт-25 төрлийн зөвлөгөө хүргэсэн.

Түвшинширээ:

Хөрөнгө оруулалтын чиглэлээр: Улсын Их хурлын гишүүн Ж.Батсуурь, Н.Ганибал нарын санаачлалаар тус сумын 2-р багийн нутаг “Цагаан өндөр”-т хээрийн сайт байгуулахаар товлогдон, үүрэн холбооны Юнител компани гүйцэтгэж, 8 дугаар сарын 25-ны өдөр хүлээлгэн өглөө.

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр 2021 онд хийгдэх ажлуудаас ковш, хог зөөврийн машин нийлүүлэх ажил 100%, сумын төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэл 50%, сумын төвийн камержуулалтын ажил 80%-тай явагдаж байна. Сумын төвийн хогийн цэгийг цэгцлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаад байна.

Сум хөгжүүлэх сангаас 8 иргэнд 69,5 сая төгрөгийн санхүүжилтийг олгох зээлийн гэрээ, барьцаа хөрөнгийн гэрээг хийж тухайн иргэдийн дансруу мөнгийг шилжүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгөөр гаргаж буй худгуудад аймгийн хөдөө аж ахуйн газар болон худаг гаргаж буй компанийн төлөөлөл явцын хяналт хийсэн. 2 худгийн гүйцэтгэл 70%, 1 худгийн өрөмдлөгийн ажил эхэлж байна.

Мөн сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2 гүн өрмийн худаг гаргуулах ажил хийгдэж байна.

Хөдөө аж ахуй, байгаль орчин: Сумын хүнсний дэлгүүрүүдэд мэргэжлийн хяналтын газраас ирсэн шалгалтын хүснэгтийн дагуу шалгалт хийж заавар зөвлөгөөг өгч 9 дэлгүүр, 2 хоолны газарт шалгалт хийж, илэрч гарсан зөрчлүүдийг арилгах арга хэмжээг авч ажиллахыг хариуцсан аж ахуй нэгж иргэнд даалгаад байна.

Монгол улсын ШУА, Боловсрол суваг телевиз хамтран тус сумын танилцуулга сум орон нутгийн түүх дурсгал уул усны талаар мэдээлэл бэлтгэн зураг авалт хийж орон нутгийн иргэдээс мэдээлэл, ярилцлага цуглуулж бэлтгэх ажилд 2 өдрийн туршид 200 км зам туулан ажилласан.

ШУА-н археологийн судалгааны ажилчдын дунд үүссэн маргааныг зохицуулж “ЭБНЭ” ХХК-ний үйл ажиллагаатай танилцаж, гэрээ хэлэлцээр байгуулах талаар ярилцаж тохиролцсон.

Тус сумын Өлзийт багийн нутаг Оорцогийн ууланд археологийн судалгааны судалгааны үйл ажиллагаа явуулж буй Монгол улсын Чингис хааны музейн үзмэр, ШУА-н үйл ажиллагаатай танилцаж судалгааны ажлын үр дүн, явцын байдалтай газар нь танилцаж холбогдох мэдээ мэдээлэл ойлголт авч нутгийн малчид ард иргэд танилцуулан ажиллаж байна.

Мал сүргийг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил сумын Засаг даргын захирамжийн дагуу хийгдэж байна. Мал угаалгын ажилд 4 ажлын хэсэг гарч 8 угаалгын ваннанд ванндаж угааж байна. Одоогийн байдлаар 40 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шүлхийн вакцин 100% хийгдэж дуусаад байна.

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гадаа талбайг ариутгаад байна.

Төсөв, санхүү:

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж: Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д бүртгэлтэй ажил хайгч бүртгэгдэж, ажлын байранд 2 иргэний мэдээллийг зуучилсан.

2017-2020 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарлагдсан төсөл хөтөлбөрт хамрагдсан 7 иргэнтэй холбогдож 450000 төгрөгийг дансанд төвлөрүүлсэн.

"Хөдөлмөрийн зах зээлийн дэх эрэлт нийлүүлэлт" судалгаа явагдахтай холбогдуулан сумын багийн Засаг дарга нартай хамтран

-Малчин өрх, 18-34 насны залуучууд, Оюутан, ААНэгжүүд, Хувиараа хөдөлмөр эрхлэгч нарын судалгааг гаргасаны зэрэгцээ Залуучуудыг орон нутагт хөдөлмөрт бэлтгэх төслийн сургалтад хамрагдах иргэдийг бүртгэх төслийн зарыг сумын орон нутгийн цахим группд олон нийтэд мэдээллийг өгч нийт 9 иргэн бүртгэлээ.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 22 өрхийн 99 иргэн хамрагдаж байгаа ба 8-р сарын 1,224,000 төгрөгийн "Хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан бүртгэл"-ийг гэрээт дэлгүүрт бэлтгэн өгч өрхүүдэд олгуулж байна. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, иргэдийн дэлгэрэнгүй судалгааг маягтын дагуу тус тус гаргасан.

08-р сард Нийгмийн халамжийн ehalamj системд "Цалинтай ээж" хөтөлбөрийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид 6 иргэнд, Жирэмсэн эхийн тэтгэмжид 5 иргэнд, шүдний хөнгөлөлт 1 ахмад, тэргэнцэр 1 ахмад, нийт 11 иргэний мэдээллийг бүртгэж тэтгэмжид хамруулсан.

Боловсролын чиглэлээр: Энэ хичээлийн жилээс нэгдүгээр ангийн сурагчдыг цахимаар бүртгэх ажил анх удаа явагдаж байна. Нэгдүгээр ангийн 96 хүүхэд бүртгүүлэхээс 77 хүүхэд бүртгүүлж бүртгэлийн хувь 80%-тай байна.

8 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд нийт багш нар БМДИ -ээс зохион байгуулж байгаа цахим сургалтад нэгдсэн зохион байгуулалттай оролцож байна.

Сургалтын орчныг сайжруулахаар сургуулийн дотоод нөөц боломжоор хичээлийн хоёрдугаар байрын анги танхимд бүрэн засвар хийлээ. Дотуур байрын сурагчдаа хүлээн авах бэлтгэлийг хийж их цэвэрлэгээ, хичээлийн байрууд болон дотуур байранд ариутгал халдваргүйтгэл хийж байна.

Мөн хичээлийн хоёрдугаар байранд цахилгааны засвар хийгдэж байна.

Соёл: Түвшинширээ сумын уугуул эртний эдлэл цуглуулагчдын холбооны нарийн бичгийн дарга Цэндийн Батсайхан нь төрөлх нутгийнхаа соёлын төвийн үйл ажиллагааг дэмжиж, сумын орон нутаг судлах танхимд 28,0 сая төгрөгийн үнэ бүхий ховор үзмэр, эртний эдлэл хандивлаж, номын санд 400 гаруй ном хандивлалаа.

Эрүүл мэнд: Эрүүл мэндийн яамнаас 65-аас дээш настай ахмадуудад тарааж буй дархлаажуулалтын багцыг сумын нийт 156 ахмадуудад хүргэлээ.

Энэ сард Коронавирусын халдвартай 56 иргэн бүртгэгдэж эмнэлэгт хэвтэн эмчлүүлж гараад байна. Уг голомтот бүсэд 2 баг 10 хоногоор ээлжлэн ажилласан байна.

Халзан:

Төрийн удирдлагын ажлын чиглэлээр: Сумын төвийн ойролцоох 4 км –т бог мал байлгахгүй байх чиглэлийг барьж ажиллаж байна. Энэ хүрээнд Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг ажиллаж 4 км дотор буусан малчидтай уулзаж, нүүх шаардлага тавьсан.

Малын хөлийн татварт нийт 420 өрхийн 94 сая орчим төгрөг төвлөрөх ёстойгоос 8 дугаар сарын 1 ний байдлаар 35 өрхийн 9 сая 1 зуу мянган төгрөг төвлөрүүлээд байна.

Хууль эрх зүйн ажлын хүрээнд: Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор "Төрийн албаны тухай болон Архив, бичиг хэргийн хөтлөлтийн тухай хуулиудын хэрэгжилт" сэдэвт арга зүйн сургалтыг 2021.08.18-ны өдөр нийт төрийн албан хаагчдад зохион байгуулж ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургууль: БСШУЯ-наас зохион байгуулсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд сургуулийн захирал, номын санч, 8-р ангийн багш хамрагдсан.

8-р сарын 16-25ны өдрүүдэд 1-р ангийн сурагчдыг цахимаар бүртгэсэн. Өнөөдрийн байдлаар 1-р ангийн сурагчдын ирцийн бүртгэл 87%-тай байна.

Байгаль орчны чиглэлээр: Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан “Хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөнд дасах зохицох чадамж болон эрсдлийн менежментийг боловсронгуй болгох нь “ сэдэвт цахим сургалтад хамрагдав.

Шонхор шувууны отгийг нэгийг орон нутагт байрлуулан 2 шонхор шувууны гэрээ байгуулан ажиллаж байна.

Газар зохион байгуулалтын чиглэлээр: Газрын кадастарын мэдээллийн сангаас 4 иргэний кадастарын зураг хэвлэж ажилласан. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийх компани тус суманд 2 хоног ажиллав.

Уулбаян:

Сумын иргэдийн төлөөлөгчдийн ээлжит бус 5 хуралдаанаар Хог хаягдлын хураамжийг шинэчлэн тогтоох тухай, Ногоон байгууламж нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг хамгаалах тухай журам батлах тухай, Сумын бэлчээр ашиглалтын журам гэсэн 3 асуудал хэлэлцүүлж Ногоон байгууламж, Хог хаягдал дэмжигдэн холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн.

Төсөв санхүүгийн чиглэлээр: Сумын ИТХ-ын ээлжит бус 5-р хуралдаан болж төсөвт тодотгол хийлээ. Үүнд Аймгийн санхүүгийн дэмжлэг 20,0 сая төгрөгөөр нэмэгдэж энэ нь Ковид 19 гарсан өр авлагыг барагдуулах чиглэлээр засаг даргын нөөцийг нэмэгдүүлсэн болно. Мөн оны эхний үлдэгдэлээс 64,0 сая төгрөгийг дутагдаж байгаа эх үүсвэрт хуваарилах, МАА-н татварыг 40,0 сая төгрөг орохоор баталж ОНХС-д ХАА-н нөөц бүрдүүлэх, хадлан тэжээл бэлтгэх, угаалгын ванн барих зэрэг ажлыг хийхээр төлөвлөв. ТЗШ-ийн байгууллагын сургууль 80,0 сая төгрөгөөр нэмэгдэж, цэцэрлэг 14,0 сая төгрөг /хүүхдийн хоолны зардал/ хасагдаж батлагдсан байна.

Худалдан авах ажиллагааны талаар: Чийрэгжүүлэлтийн танхим байгуулах тендерийг зарлаж 35,0 сая төгрөгөөр Санаа мед трейд ХХК шалгарч гэрээ байгуулах эрх олгоод гэрээг байгуулсан.

Жавхлантын багт 1500 м ЦДАШ-ын тендерийг 2 удаа зарлаж тендерт оролцох хүсэлт ирүүлсэн компани гараагүй тул хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж тендерийг дахин зарлахаар шийдвэрлээд байна.

ЭМТ-ийн урсгал засвар УТХО-аар 35,0 сая төгрөгийн тендер зарлах зураг төсвийг хийлгүүлээд байна.

Ногоон байгууламжийн чилэлээр: Сумын жишиг хорооллын ногоон байгууламжийн хашааны эвдрэл гэмтлийг засах, засвар үйлчилгээний ажлыг хийж дууслаа. Хашааг өндөрлөх ажилд зорилтот бүлгийн иргэдээс сонгон авч ажилуулсан. Мөн сумын төвийн Баясгалант талбайн ногоон байгууламжийн хашаа засварлах, будах, сэргээх ажлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэлээ.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Ус цаг уурын байгууллагын мэргэжилтэнтэй хамтран бэлчээрийн ургамлын даац багтаамжийг тодорхойлох, үр дүнг үнэлэх ажлын хүрээнд олон улсад ашиглаж байгаа шугам цэгийн аргачлалаар сум бүрд тогтоосон ажиглалтын цэг дээр даац тодорхойлох ажлыг зохион байгуулж, өвөлжилт хаваржилтын нөхцөлд үнэлэлт, дүгнэлт гаргах ажлыг хийсэн. Уг ажлын хүрээнд Тэгш, Бага цагаан, Долоон хашаат, Ац болон Дэрсэн худаг гэсэн 5 цэгийн 10 шугамнаас бэлчээрийн даац тодорхойлох дээж авах ажлыг 2021 оны 08 дугаар сарын 09, 10-нд хийж гүйцэтгэсэн.

Иргэдээс ирсэн хадланд гарах хүсэлтийг хүлээн аймгийн ХХААГ-т хүргүүлсэн. Мөн хадлангийн техникийн судалгааг авч 2021 оны 07 сарын 29-нд хүргүүлсэн.

Эрүүл мэндийн төв:

Үзлэгийн мэдээ 2021 оны 07 –р сарын 23 ны байдлаар

	Нэрс	Тоо
1	Урьдчилан сэргийлэх үзлэг	1217
2	Амбулаторийн үзлэг	966

3	Идэвхтэй хяналт	49
4	Гэрийн эргэлт	83
5	Гэрийн дудлага	179
6	Алсын дуудлага	109
7	Артерийн даралт	560
8	Чихрийн шижин	692
9	Хөхний үзлэг	377
10	Эсийн шинжилгээ	58
11	0-2 насны хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилга	202
12	Ковид-19 дархлаажуулалт вакцинд хамрагдсан	1, 2-р тун 3243, Пейзер вакцин -16-17 нас, жирэмсэн, архаг хуучтай-294 иргэн хамрагдаад байна.
13	Түргэвчилсэн тест	762
14	ПГУ шинжилгээ	256
15	Гэрийн тусгаарлалт, ажиглалтад байгаа	0
16	Гэрийн ажиглалтад байгаа	0

Ерөнхий боловсролын сургууль : 2021-2022 оны хичээлийн жилд 75 хүүхдийн ортой, дотроо гал тогоо, халуун ус, ариун цэврийн байгууламж бүхий дотуур байр ашиглалтад орлоо.

Мобиком корпорациаас санаачлан Дэлхийн Зөн Монгол ОУБ-аас хэрэгжүүлж буй “Ухаалаг боловсрол” төслийн судалгаанд 6-15 насны 25 сурагч хамрагдаж дараагийн шатны уралдаанд оролцох эрхийг авлаа.

БМДИ-ээс зохион байгуулсан “ЕБС-ийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах” цахим сургалтад 24 багш, удирдах ажилтан хамрагдлаа.

Хүүхдийн цэцэрлэг:Багш, ажилчдад зориулсан “Багшийн ёс зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 16 хүнийг хамрууллаа.

Өмнөх хичээлийн жилд сургалтад хамрагдаж байсан 4-5 настай хүүхдийн эцэг эхтэй холбогдон бүртгэж баталгаажууллаа.

08.19-20-ны өдрүүдэд цэцэрлэгт шинээр элсэх 4-5 настай хүүхдийн бүртгэлийг зохион байгуулж, бүртгэл 48%-тай байна.

Байгууллагын гадаад болон дотоод орчны эрсдэлийг тооцож хариу арга хэмжээ авч ажиллаж байна.

Эрдэнэцагаан:

Ковид-19 цар тахлын чиглэлээр авсан арга хэмжээний талаар:Халдварт өвчнөөс сэргийлэх вакцинд 8 сард нийт 299 хүнийг хамруулж Үүнээс: Ковид 19 халдварын эсрэг Вероцилл-35 , Пфайзер -264 хийж дархлаажуулж вакцинд хамрагдсан иргэдийн мэдээллийн health.gov.mn программд шивж баталгаажуулсан. Мөн товлолын вакцинд 32 хүүхдийг хамруулсан.

Хүн амд урьдчилан сэргийлэх болон идэвхитэй хяналтын үзлэгийг эмч нарын үзлэгийн хуваарийн дагуу гэрийн эргэлтэнд шилжүүлж 8 сард ойрын дуудлагаар 417 хүн үзэж, стационараар 29 нийт хүнийг хэвтүүлэн эмчлүүлээд байна. Хүлээн авах, яаралтай тусламж үйлчилгээг 57 хүнд хүргэн ажилласан.

8-р сард нийт 179 хүнээс шинжилгээ авч үүнээс PCR -20 хүнээс, түргэвчилсэн оношлуураар 159 хүнээс тус тус авсан. PCR шинжилгээний сорьцыг тээвэрлэн 4 удаа АНЭ-т хүргэсэн. Нийт 159 хүний шинжилгээг mohs.mn программд шивж баталгаажуулсан.

Ариутгал халдваргүйтгэлийг өдөр бүр больнец, машин, шинжилгээний цэгт нийт 1200 мкв талбайд хийж гүйцэтгэн ажиллаж байна.

ЭМТ-ийн амбулаторт ор дэлгэн тусгаарлах байр болгосон ба тусгаарлах байранд одоогоор 5 хүн эмчлүүлж байна. Эдгээрийн ойрын хавьтал 29, дам хавьтал-22 нийт 51 хүн гэрийн тусгаарлалтанд байна. Гэрийн ажиглалтанд хүн байхгүй.

Ковид-19 цар тахалтай холбогдуулан Эрүүл мэндийн төвд тусгаарлан ажиглалтын 21 ортой 8 өрөөг бэлдэж бэлэн болгосон.

Засаг даргын тамгын газар: Засаг даргын тамгын газарт 8 дугаар сард нийт 5 өргөдөл ирснээс ажилд орохыг хүссэн-2, тусламж хүссэн -3 өргөдөл гомдол ирснээс шийдвэрлэсэн-2, хугацаа болоогүй -3 өргөдөл байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлтэй 10 иргэнтэй цахимаар холбогдож зээлийн эргэн төлөлт хийх талаар мэдэгдэл хүргүүлж 3 зээлдэгч зээлээ бүрэн төлж барагдуулсан.

Малчин иргэдийн 393 ширхэг ноосны урамшуулалын падаан хүлээн авч шивэлт сүхбаатар аймгийн Хөдөө аж ахуйн газарт тушааж ажилласан.

Нийгмийн хамгааллын чиглэлээр: Хүүхэд хамгааллын даатгалд даатгагдсан 11 хүүхдийн амьдарч байгаа өрхийг нэмж хамтарсан багийн хяналтанд байдаг 2 өрх нийт 13 өрхийн мэдээллийг /1 өрхийн 68 асуумжтай/ шивж аймгийн ГБХЗХГ-т хүргүүлэв.

ЭМТ-д 60 болон түүнээс дээш насны 454 ахмадын тоон судалгааг баг тус бүрээр гаргаж өгөв.

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар